


ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ГАЛТ ЗЭВСЭГ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, БИЕЙН ХҮЧ ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ



Г.ХОСБАЯР

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр
Гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт,
гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хошууч*



Э.ӨНӨБОЛД

*Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр
Гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт,
гүйцэтгэх ажлын тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад*

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх хэрэгцээ шаардлага, хэрэглэх үндэслэл, анхаарах асуудлыг тодорхойлж, тулгамдаж буй тодорхой асуудлуудыг судлаачдын зүгээс илэрхийлсэн.

Abstract: The researcher identifies needs, rationales and issues with respect to the use firearms, special weapons and force by officers from the Court Decision Execution Authority and government authorities with special mandates and takes into account challenges faced.

Түлхүүр үгс: Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, алба хаагч, үндэслэл, хор уршиг, анхаарах асуудал, аюулгүй байдал.

Key words: government authorities with special mandates, firearms, special weapons, force, an officer, rationales, consequences, issues, and security.

Монгол Улсын Үндсэн хууль хийгээд олон улсын хэм хэмжээ, дотоодын хууль тогтоомжуудаар хамгаалагдсан хүний эрхийн нэг асуудал бол хүний халдашгүй байх эрх билээ.

Хэнд хүч хэрэглэх, эрх, эрх чөлөөнд халдах үйлдэл аль ч нийгэмд хязгаарлагддаг ойлголт гэдгийг бид мэднэ. Гэсэн хэдий зайлшгүй шаардлагаар тэрхүү хамгаалагдсан эрхийг зөрчих нь бий.

Миний эрх бусдын эрхээр хязгаарлагддаг эрх зүйт төрийн зарчмыг бид мэддэг. Энэхүү хязгаарлалтын бүрэн бүтэн байдлыг хангах, энэ зарчмын хэрэгжилтийг хамгаалах механизм нь төр буюу төрийн албадлага байдаг. Тэгвэл хүний эрхийг хангах, хамгаалах чиг үүрэгтэй институт болох төр тэрхүү эрхийг зөрчихийн тулд эрх зүйн зохицуулалт, хэрэгцээ шаардлага, нарийн стандартыг шаардах нь зүйн хэрэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”¹ гэж заасан нь аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааны үндсийг тодорхойлж, энэхүү ажиллагаа нь хамтын ажиллагаагаар илэрхийлэгддэг.

Дээрх төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг холбогдох хууль, тогтоомжид хуульчилсан бөгөөд зарим тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдаж, хязгаарладаг ба энэхүү хуулиар хамааруулсан чиг үүргийг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, түүний албан тушаалтан, ажилтан гүйцэтгэдэг.

Үүнд: зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, тус байгууллагуудын офицер, ахлагч, шинжээч, мэргэжилтэн, шийдвэр гүйцэтгэгчийг хамруулан ойлгож болно².

Эдгээр байгууллагууд нь нийтлэг шинжээрээ хүний халдашгүй байх, хүч хэрэглэхээс ангид байх эрхэд тодорхой хэмжээгээр халддаг бөгөөд бүгд хуульд заасан үндэслэл, журмыг удирдлага болгдог.

Хуулиар хамгаалах ёстой эрх, ашиг сонирхол руу халдах шаардлага үүссэн бол түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт, хэм хэмжээ, протокол нь нарийвчилсан оновчтой, аливаа зөрчил, хийдлийг дагуулахгүй байх хэрэгтэй гэдгийг дурьдах нь зөв.

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он №1

² Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №01

Харин энэхүү тусгай чиг үүрэг бүхий байгууллага ямар эрх зүйн зохицуулалтын хүрээнд хүний язгуур эрх, ашиг сонирхолд халдаж байгааг энэхүү судалгааны хүрээнд дурьдсан болно.

Үндсэн хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд дунд ихээхэн онцлог бүхий чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.1-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага мөн”³ гэж хуульчилсан.

Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэх явцад буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны /иргэний, эрүүгийн, зөрчлийн болон захиргааны/ явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч⁴ нь аливаа аюул заналхийлэлд өртөх явдал гарсаар байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтэд шууд болон шууд бусаар нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болж байна.

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, тухайлбал Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий ассамблейн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”⁵..., Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална”⁶..., “энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах”⁷ үүрэг хүлээх тухай ч зааж өгчээ.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 он, №24

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270.1-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын алба хаагчаас бүрдэнэ гэж заасан.

⁵ НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он, 3 дугаар зүйл

⁶ НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он, 6 дугаар зүйл

⁷ НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966, 3 дугаар зүйл

Мөн Монгол улсын Үндсэн хуульд “Монгол улсын иргэн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй⁸” гэж тус тус хуульчилж өгсөн нь төрийн тусгай алба, тэр дотроо ШШГБ-ын алба хаагчдад ч нэг адил хамаарна.

Манай улсад эрт үеэс “Төрөө дээдлэх”, “төр, түүний алба хаагчдад хүндэтгэлтэй хандах” үзэл, ёс бодитойгоор оршиж ирсэн уламжлалтай ч нийгмийн суурь үзэл бодол, философийн үзэл баримтлал бүхэлдээ өөрчлөгдөж /төрийн үүрэг бол ард түмэнд үйлчлэх явдал мөн/ нийгмийн бүлгүүдийн төрдөө итгэх итгэл үнэмшил, сэтгэхүй ихээхэн хэмжээгээр өөрчлөгдсөн.

Зарим тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь урьд өмнө төрийн өндөр албан тушаал хашиж байсан, нийгэмд нөлөө бүхий хүмүүс байдаг нь шийдвэр гүйцэтгэгчийг албан үүрэгтэй нь холбогдуулан түүний тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, өөрт ашигтайгаар шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, нөлөөлөх, мөн түүнчлэн төлбөр төлөгч, ялтан нь сэтгэл зүйн хувьд өөрчлөлттэй, тогтворгүй байдаг нь шийдвэр гүйцэтгэгчийг заналхийлэх, эрүүл мэнд, амь насанд нь хүч хэрэглэн халдах зэргээр түүний аюулгүй байдалд сөргөөр халддаг.

Түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг нохойгоор хазуулсан, хутга тулгаж дарамталсан, толгойн болон биеийн бусад хэсэгтээ цохиулсан, боомилсон, хувийн өс санаж зодсон, дарамталсан, хувцсаа уруулсан, хэл амаар доромжилсон, зэвсгийн чанартай зүйл барьж айлган сүрдүүлсэн болон галт зэвсэг хэрэглэж амь насанд халдсан гэмт хэрэг гарч байсан нь та бидний эргэн тойронд аюул заналхийлэл ойрхон байгааг гэрчилнэ.

Албан үүргээ гүйцэтгэж байгаа алба хаагчдын аюулгүй байдлын тогтолцоо, баталгаа, соёл хангалттай бүрэлдэн төлөвшөөгүйн улмаас тэдний болон гэр бүлийн гишүүдэд нь хоригдол, хоригдогч этгээд, төлбөр төлөгчийн зүгээс халдах, үйл ажиллагаанд нь хүч хэрэглэн эсэргүүцэл үзүүлэх зэргээр нөлөөлөх оролдлого, аюул заналхийлэл улам бүр нэмэгдэх хандлагатай боллоо.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хорих байгууллагын аюулгүй байдал, хоригдол, хоригдогчийн эрхийг хамгаалах болон

⁸ Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Төрийн мэдээлэл сэтгүүл №1.

байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг шат дараатай авч байгаа хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байран дахь эрсдлийн түвшинг үнэлж дүгнэх, түүнд нийцсэн холбогдох арга хэмжээнүүдийг авах хэрэгцээ, шаардлагатай.

Аюулгүй байдлын орчин нөхцөл хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөө үед учирч болох аюул заналхийллийг урьдчилан танин мэдэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нөөц боломжийн харилцан хамаарлыг судлах, эрсдлийг үнэлэх, даван туулах үйл ажиллагааны бодлого, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг бий болгох сорилтууд тулгарч байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд нь эрх зүйн бүрэн чадамж бүхий, эрх зүйн харилцаанд чөлөөтэй оролцогч иргэн, хүнд тодорхой ажиллагааг хийдэг бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа галт, зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагааг хэрэгжүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үйл ажиллагааны онцлог чиг үүргээс шалтгаалан шийдвэр гүйцэтгэгч, хорих байгууллагын ажилтнаас бүрддэг⁹ бөгөөд тэдгээрийн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх үндэслэл, шаардлага нь харилцан адилгүй байдаг.

Хэдийгээр хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч галт, зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх эрхтэй гэж заасан боловч шийдвэр гүйцэтгэгчийн хувьд түүний шаардлагыг эсэргүүцсэн, өөрийгөө хамгаалах зорилгоор нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх эрхтэй байдаг бол хорих байгууллагын алба хаагч биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хэрэглэх эрхтэй.

Алба хаагчийн зүгээс галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагааны тухай ярих нь тэдгээр ажил үүргийн онцлогтой холбоотой тул тэдгээрийн онцлогийг дурах зүйтэй гэж үзэж байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааны хувьд:

Шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх баримт бичиг, хоригоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авсан

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2017. №24

шийдвэрийг биелүүлдэг. Энэ нь улсын хэмжээнд иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, зөрчлийн хэргийн шүүхээр баталгаажсан гүйцэтгэх баримт бичгээр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг гүйцэтгэх бөгөөд нөгөө нийгмийн дунд буюу хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, төлбөр төлөгч, шийтгэл хүлээсэн этгээдтэй харилцдаг ба тэдний хувьд эрх, эрх чөлөөний хязгаарлалтын хувьд харьцангуй бага байдаг нь шийдвэр гүйцэтгэгчид халдах, хүч хэрэглэх эрсдэл харьцангуй бага байдаг.

Хорих байгууллагын алба хаагчийн хувьд:

Хорих байгууллагын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, байнгын хяналт, хамгаалалтын дор тусгай дэглэм бүхий байгууллагад нийгмээс тусгаарладагаараа онцлогтой. Цагдан хоригдогсад болон хоригдлууд, баривчлагдсан этгээдүүдтэй харилцдаг. Энэ ч утгаараа хорих байгууллагын алба хаагчийн хувьд эрсдэл харьцангуй өндөр гэж үзэж болно. Учир нь эрхийн хязгаарлалт хэдий чинээ их байна, төдий чинээ тухайн субъектын харилцаа хандлага, илүү их эрсдэл дагуулдаг нь ял эдлүүлэх ажиллагааны үйл явц, туршлагаас харагдаж байна.

Хуулиар хамгаалсан эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн тул эрхээ хязгаарлуулсан гэмт хэрэгтэн бие хүний эсрэг, тодорхой шаардлагыг хангаж биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бөгөөд нөгөөтэйгүүр уг ажиллагааны нийтлэг зарчим болох учирч болох эрсдлээс илүү хохирол учруулахгүй байх шаардлагатай.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх эрх зүйн зохицуулалтын нарийвчилсан хэм хэмжээг шаарддаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог бол бүхлээрээ албадлагын арга хэмжээ байдаг. Аливаа шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон үеэсээ хойш зохигчдод тухайн шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг олгодог бөгөөд сайн дураар биелүүлэх хугацаа өнгөрсөн нь тухайн шийдвэрийг албадан биелүүлэх шаардлага үүсдэг.

Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь мөн адил хуульд заасан ялыг гэмт этгээдэд албадан эдлүүлснээрээ хуульд заасан цээрлүүлэх хэм хэмжээ биелэлээ олдог билээ.

Иймд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед алба хаагчаас буюу төрөөс хэрэгжүүлэх албадлага нь тухайн ажиллагааны аюулгүй байдлыг галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчээр хангах асуудал зайлшгүй шаардлагатай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагааны үед дараах зарчмуудыг баримталдаг. Үүнд:

1. Зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэх,
2. Нэн тэргүүнд хэрэглэхгүй байх,
3. Тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, ингэхдээ хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.

Дээрх зарчмуудад нийцүүлэн галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагаа нь хэрэглэхийн өмнөх нөхцөл байдал, хэрэглэх, хэрэглэсний дараах гэсэн гэсэн 3 үе шатыг заавал туулдаг. Энэ үе шатыг галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх эрх зүйн зохицуулалтууд зохицуулах дамжиггүй.

Өмнөх нөхцөл байдлын хувьд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх үндэслэлүүдийг хамааруулан ойлгож болох юм.

Дараах үндэслэлүүдийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үед, хорих байгууллагын үйл ажиллагааны үед гэж ангилж болно.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон,

- Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй ялтан, хоригдлыг баривчлах үед,

- Хоригдол хорих ангийн алба хаагчийн тавьсан шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцсэн,

- Алба хаагчийн аюулгүйн тойрогт зөвшөөрөлгүй нэвтэрсэн,

- Хоригдлыг хуяглан хүргэх, хуяглан хүргэж байгаа хоригдлыг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон,

- Хяналтад байгаа хоригдол амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлж болзошгүй бол тэдгээрээс урьдчилан сэргийлэх,

- Хорих байгууллага дотор гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хяналтдаа авах, хорих байгууллага доторхи аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, хорих байгууллагыг бүслэн хаасныг чөлөөлөх,

- Хорих ангид бүлэглэн халдсан,
- Хорих ангийн дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, эсхүл хорих ангид гарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох,
- Хоригдол оргон зугтсан, оргохыг завдсан,
- Хоригдол өөрийн, бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон,
- Галт зэвсэг, эсхүл хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хоригдол зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн,
- Хорих ангид эмх замбараагүй байдал үүсч, хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон.

Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх.

Өмнө хэсэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх үндэслэл, эрхийн тухай авч үзсэн бол ямар төрлийн галт зэвсэг, тусгай хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаар авч үзье.

ШШГБ-ын үйл ажиллагаанд хэрэглэх галт зэвсгийг албаны нууцад хамааруулдаг бөгөөд 4 бүлэг 27 төрлийн тусгай хэрэгслийг албаны тусгай зориулалтаар ашиглаж байна¹⁰. Галт зэвсгийг журамд зааснаар үндэслэл бий болсон үед гадна орчинд нэг удаа дээш хий буудан анхааруулах бөгөөд барилга байгууламжид хэрэглэх бол амаар анхааруулна¹¹ гэж заасан.

Гэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа гэмт үйлдэл, хор уршиг учруулж болзошгүй үйлдлийг таслан зогсоох зорилгоор гүйцэтгэж байгаа ажиллагаа тул ямагт хүний амь насанд халдахгүй байх, амин бус газар галт зэвсэг хэрэглэхийг санах нь чухал.

Тусгай хэрэгслийн тухайд хэрхэн хэрэглэх зохицуулалтыг харьцангуй тодорхой заасан байдаг бөгөөд гавны тухайд гарын, хурааны, гар, хөлийн гавыг хэрэглэдэг. Ингэж хэрэглэхдээ хоёр гарыг биеийн урд болон ард бугуйгаар холбож, гар хөлийг холбож, бүсэлхийд зүүсэн бүстэй холбож, хоёр ба түүнээс дээш хүнийг гавлах зэргээр гавладаг.

¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгслийн жагсаалт. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал. 2019.

¹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтрсан тушаал. 2017.

Гав хэрэглэсэн тохиолдолд түлхүүрээр нь чангалж, гавлагдсан этгээдийн гар, хуруунд шигдэх, цус боох, амь нас эрүүл мэндэд нь хохирол учруулж болзошгүй байдлыг тогтмол шалгах шаардлагатай.

Хэрэв ороох цамц хэрэглэсэн бол нэг цагаас илүү удаан хугацаагаар хэрэглэхийг хориглогдог.

Мөн үүнээс гадна резинен бороохойг хүний яс, булчин дагуу ороолгох, цохих, хатгах байдлаар үйлдлийг таслан зогсоох зорилгоор хэрэглэх ба ингэхдээ алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаар довтолсоноос бусад тохиолдолд хүний толгой, хэвлий бөөр, давсанд цохихгүй байхыг эрмэлзэнэ.

Үүнээс гадна цахилгаан хүчдэлээр цохиулагч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч зэргийг хэрхэн хэрэглэх талаар заасан байдаг¹².

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийн хувьд түүнийг хэрэглэх хэмжээ, дэс дараалал, арга хэлбэрийг тодорхой төлөвлөсний үндсэн дээр хэрэглэх ба хэрэглэсний дараа гэмтсэн, шархадсан хүмүүс байгаа эсэхийг нягтлах шаадлагатай байдаг.

Биеийн хүчийг үүссэн нөхцөл байдалд тохируулан бие хамгаалах, үйлдлийг таслан зогсоох, хяналтад авах зорилгоор хориглоогүй бүх төрлийн барилдаан, тулааны мэх хэрэглэж болох ба эхний мэхийг хийсний дараа хор аюул арилаагүй нөхцөлд давтан болон өөр мэхийг сонгож, үргэлжлүүлэн хэрэглэнэ.

Дээрх байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх журмыг заасан байх ба энэ талаар товч дурдлаа.

Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэсний дараах үед.

Тусгай чиг үүрэг бүхий байгууллага хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан ч гэсэн аливаа үйл ажиллагаа заавал тодорхой үр дүнд хүргэнэ. Энэхүү үр дүнг зөв тодорхойлох, хууль журмын дагуу явагдсан эсэхийг тодорхойлох ажиллагаа галт, зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хэрэглэсний дараа явагддаг.

Хорих байгууллага болон хорих ял эдлүүлэх албаны алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн бол ангийн даргад даруй мэдэгдэх бөгөөд үүний улмаас

¹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтрсан тушаал. 2017.

хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол хорих анги, байгууллагын дарга, харьяа прокурорын газар, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын жижүүрт даруй мэдэгдэж хэргийн газрыг хамгаалалтад авах бөгөөд галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх хуудсыг журамд заасны дагуу холбогдох мэдээллүүдийг үнэн зөв бичиж, тэмдэглэж, ангийн даргад хүлээлгэн өгөх ба энэхүү илтгэх хуудсыг 3 хувь үйлдэнэ. Энэ талаар хорих байгууллагын дарга ШШГЕГ-т мэдэгдэж, бичгээр таницуулна. Уг асуудалд ШШГЕГ-аас албаны шалгалт явуулах бөгөөд шалгалтын дүнг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий прокурор Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст тус танилцуулдаг.

Харин тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэсэн тохиолдолд бүрт алба хаагч энэ тухай тэмдэглэл үйлдэх шууд захирах даргад даруй мэдэгдэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагааг дээрх байдлаар зохицуулж байгаа бөгөөд холбогдох хууль журмуудыг удирдлага болгон ажиллаж байна. Эдгээрийг дурдвал:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх тухай журам,
- Хорих байгууллагын ажилтан галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээллэх журам,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгслийн жагсаалт,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэрэглэх тусгай техник хэрэгсэл, галт зэвсэг, сумыг бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журам зэрэг болно.

Дээрхээс үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн тусгайлсан чиг үүрэг болох иргэнийхээ амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэх чиг үүргийг эрх хэм хэмжээнд үндэслэн зохих төвшинд хэрэглэж байгаа харагдаж байгаа боловч энэхүү ажиллагаанд бодит амьдралд тулгамдсан хүндрэл бэрхшээл байсаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудын талаар товч авч үзье.

Хэдийгээр хуулиар олгосон эрх, хэмжээний хүрээнд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүчийг хэрэглсэн нь хуулийн дагуу үйлдэл мэт тухайн нөхцөл байдлыг хэрхэн үнэлж, хэрэглэхийн өмнө, хэрэглэх, хэрэглэсний дараах шатуудад алба хаагч биеийн, сэтгэл зүйн, хууль зүйн мэдлэгтэй, тодорхой хариулт өгөх мэдлэгтэй байхыг цаг үе шаардах болсон нь нууц биш юм.

Нийтийн хэв журам зөрчсөн иргэнд зарим тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэх нь харьцангуй хялбар бөгөөд тухайн иргэн өөрийн буруутай үйлдлийг ойлгох, түүнийгээ хүлээн зөвшөөрдөг.

Харин хорих байгууллагад тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх нөхцөл байдал нь маш хүнд нөхцөл байдаг бөгөөд үүнээс өөр аргагүй тохиолдлууд байдаг. Энэ үед хоригдол, хоригдогчийн зүгээс алба хаагчийн аливаа үйлдлийг мушгин гуйвуулах, алдаа дутагдлыг соргог олж хардаг нь хорих байгууллагын үйл ажиллагааны үед биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх ажиллагааг төвөгтэй болгодог.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч болох хорих байгууллагын ажилтанд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, шийдвэр гүйцэтгэгчийн хувьд тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх дадлага сургуулилт хийх боломж хомс тухайн нөхцөл байдал галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх чадвар хомс хууль зүйн алдаа хийдэл гаргах, эсхүл уг ажиллагааг хэрэгжүүлэх шатандаа, хэрэгсжүүлсний дараах үед холбогдох материал бүрдүүлэхдээ алдаа дутагдал гаргах нь элбэг байдаг.

Тодруулбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар шийдвэр гүйцэтгэгчийг шийдвэр гүйцэтгэгчийн сонсон шалгаруулалтад тэнцсэн, эрх зүйч мэргэжилтэй, Монгол Улсын иргэн байхаар заасан байдаг ба тухайн иргэн тусгай, хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх чадваргүй, энэ төрлийн сургалтад хамрагдаагүй зэрэг асуудал байсаар байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 260 дугаар зүйлийн 260.1.1-т Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах”, 260.1.7-д “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил

гаргахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг арилгах, дотоод хяналт-аюулгүй байдлыг хангах”, 260.2-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага энэ хуулийн 260.1.7-д заасан чиг үүргийн хүрээнд... байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангана” гэж заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангах асуудал Хорих ял эдлүүлэх албаны харьяа харуул хамгаалалт, гүйцэтгэх албаны чиглэлд хамаарагдаж ирсэн уламжлалтай бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2013 оны А/18 дугаар “ШШГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” тушаалаар бүтцийн өөрчлөлт хийгдэж ШШГЕГ-т Аюулгүй байдлын хэлтэс байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар тухай хэлтсийн бүтцэд 2014, 2015 онд өөрчлөлт орж өргөжин зохион байгуулагдсан.

Тус газраас 2016, 2017 онд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгч нарт аюулгүй байдал, тусгай хэрэгсэл хэрэглэх арга зүйн хүрээнд тодорхой сургалт зохион байгуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд учирч болох эрдлийг газар дээр нь үнэлэн шалтгаан нөхцөлийг тогтоох, шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлын хангах чиглэлээр судалгааны ажил хийх, мэдээллийн сан бүрдүүлж, шийдвэр гүйцэтгэгч нарт шаардлагатай тусгай хэрэгслийн судалгааг гаргаж Ерөнхий газрын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 285.5-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй” гэж заасан нь шийдвэр гүйцэтгэгч албан үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндээ хамгаалах зорилгоор биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/260/А/112 дугаар хамтарсан тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам”-ыг батлан гаргасан.

Улсын хэмжээнд 237 шийдвэр гүйцэтгэлийн тойрог байгаагаас 17 тойрогт шийдвэр гүйцэтгэгч томилогдоогүй байгаа бөгөөд 220 тойргийн шийдвэр гүйцэтгэгчдийг хүйсийн байдлаар авч үзвэл эрэгтэй 86, эмэгтэй 134 шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байна.

Шийдвэр гүйцэтгэгч нарт тусгай хэрэгслийн хангалт дутмаг, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэх ур чадвар, дадал хангалтгүй байгаагаас өөрийгөө аливаа эрсдлээс хамгаалж чадахгүйд хүрч байна.

Дүгнэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал болон удирдлага зохион байгуулалтын хүрээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчинд алба хаагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу иргэний болон тусгайлсан эрхээ эдэлж, аюулгүй байдлаа хамгаалуулах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байна.

Тухайлбал шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь албан үүргээ хэрэгжүүлсний төлөө ямар ч тохиолдолд халдлагад өртөхгүй халдашгүй дархан байх, гэмт халдлагад өртсөн тохиолдолд зөрчигдсэн эрхийг сэргээх нөхцөл боломжийг хууль болон журамд тодорхой заасан.

Өөрөөр хэлбэл бие, эд эрхтэнд, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдсан тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг хууль, журамд заасан үндэслэлийн дагуу хэрэглэж өөрийгөө хамгаалах, хэл амаар доромжлох, гүтгэх, халдах тохиолдолд холбогдох байгууллагаар шалгуулж Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх боломжтой.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын байранд дахь эрсдлийг үнэлгээг иж бүрэн явуулж дүгнээгүй, хорих байгууллагын алба хаагчийн тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх дадал, ур чадвар дутмаг, мөн тухайн төлбөр төлөгч нь урьд өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, сэтгэл зүйн хувьд ямар өөрчлөлттэй болох зэргийг урьдчилан мэдэх боломжгүй, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал их, хууль, журамд заасан тусгай хэрэгслээр бүрэн хангагдаагүй, түүнийг хэрэглэх арга зүйд дутмаг, аюулгүй байдлын асуудалд ач холбогдол төдийлөн өгдөггүй зэргээс эрсдлийн хүчин зүйлсийг бий болгосоор байна.

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 139 дүгээр зүйлд “Шийдвэр гүйцэтгэгч нь резинен болон хуванцар сумтай буу, нулимас асгаруулагч хэрэглэнэ” гэж заасан байсан боловч одоо мөрдөгдөж

байгаа хуулиар ямар төрлийн нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглах зэргийг тодорхой хуульчлаагүй.

Мөн байгууллагын хэмжээнд бүх шатны эрсдлийн үнэлгээг хийх ажил явагдаж байгаа боловч энэ талаарх сургалт, мэдээлэл, мэдлэг хангалтгүй байгаагаас батлагдсан заавар, аргачлалын дагуу бүрэн төгс хийгддэггүй.

Хорих байгууллагын ажилтан, шийдвэр гүйцэтгэгчид практикт суурилсан сургалт, дадлага хийлгэхгүй байгаагаас үүдэн уг ажиллагааг гүйцэтгэхдээ алба хаагч алдаа, дутагдал гаргах, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахад аюул, эрсдэл үүсч болзошгүй байна.

Санал:

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/247/А167/303 дугаар хамтарсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив” батлах тухай тушаалаар ажлын ачааллын тэнцвэржүүлж, хорих байргууллагын болон шийдвэр гүйцэтгэгчийн орон тоог нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нарыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангах,

Биеийн хүч, тусгай хэрэгсэл арга зүйд сургах, холбогдох сургалтыг тогтмол явуулах,

Биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх ажиллагааг тодорхой нөхцөл үүсэхээс эхлэн тухайн ажиллагааг хийж гүйцэтгэх, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэсний дараах үе шатыг хамарсан байдлаар сургалтыг зохион байгуулах зэрэг болно.

Ашигласан материал

Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он №1
2. Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2018. №01
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 он, №24